

МОНГОЛ ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН ФРАНЦ ЗОХИОЛ, БҮТЭЭЛ

Б.Алтангүл⁵¹

Монгол Францын харилцаа эртнээс улбаатай билээ. Илхаан Аргун, Өлзийт нар Францын Гоо Филиппт захидал илгээж, IX Луй вангийн санал сэдлээр Рубрук Монголын эзэнт гүрэнд XIII зуунд зорчиж, анхны элчийн харилцааны хэлбэртэй байсан. 1965 онд БНМАУ, БНФУ-ын хооронд дипломат харилцаа тогтоож, Монгол, Франц улсын төв хэвлэлүүдэд албан мэдээ нийтлэгдсэн байдаг.

1921 оны Хувьсгалын дараа “Өрнөд Европын улсуудаас Герман, Англи зэрэг улстай юуны өмнө худалдаа хөгжүүлэхийг зорьж байсан бол Франц улстай соёл боловсрол, шинжлэх ухааны салбарт харилцах зорилт тавьж байжээ. 1927 оны эхээр Д.Аюурзана, Ж.Дүгэрсүрэн, Намсрай, Б.Уртнасан нарыг Франц улсад суралцуулахаар илгээжээ. Эдгээр оюутнуудыг эдийн засгийн чиглэлээр голлон сургахыг зорьсон байна. Мөн Франц улс бол Монгол улсыг НҮБ-д элсэхийг анхнаас нь дэмжсэн Өрнөд Европын анхны улс байжээ”⁵².

Ер нь “Европ дахины олон улсын дотроос шашны хүрээгээр бус улс төрийн хүрээнд Монголыг анх анхааран судласан орон гэвэл Франц бөлгөө” хэмээн эрдэмтэн Ц.Шагдарсүрэн онцлон тэмдэглэсэн байдаг нь уг хоёр орны харилцааны тухайд их чухал санаа хөндсөн байна.

Бид энэ удаад Франц зохиол бүтээлийн орчуулгын тоймыг он дарааллаар нь авч үзэхийг зорьсон юм.

XX зууны эхэн үеэс өрнө зүгийн тэр тусмаа францын уран зохиолын орчуулга асар хурдтай хөгжиж, олон арван бүтээл уншигчдад хүрчээ.

“Дэлхий дахины утга зохиолд гүнзгий нөлөөлдөг утга зохиолуудын нэгэнд Францын утга зохиол орно. Раблэ, Мольер, Вольтер, Дидро, Бальзак, Гюго, Стендаль, Флобер, Мопассан, Золя, Франс, Роллан болон Францын бичгийн бусад их хүмүүсийн нэр улс болгонд түгэж уншигч бүрийн зүрхийг донсолгож, сэтгэлийг баясган, ядрах цагт хүчийг нэмж, нойрмоглох үед ухааныг сэргээж байна” хэмээн орчуулагч Ж.Намсрай⁵³ дурьдсан байна.

Ер нь монгол хэлнээ орчуулсан франц бүтээлийг орчуулсан он дарааллаар нь доорхи байдлаар авч үзэж болох талтай гэж бид үзэж байна.

- а. 1913-1960 (орчуулгын суурь баттай тавигдсан үе)
- б. 1960-1975 (орчуулгын оргил үе)
- в. 1975-1990 он
- г. 1990 оноос өнөөг хүртэл.

⁵¹ МУИС, ШУС, ХУС, Европ судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D)

⁵² Оюунгэрэл Л, *Монгол, Францын харилцаа*, УБ, 2003.

⁵³ Намсрай Ж, *Францын утга зохиолын түүх*, УБ, 1997, 2-р тал.

а. 1913-1960 оны үеийн орчуулгын бүтээлийн онцлог

XX зуунд Монголын орчуулгын түүхэнд эргэлт гарч орчуулгын үйл хэрэг дорно зүгийн соёлын хүрээнээс халин гарч түүний олон төрөл зүйл мэдлэгийн бүх салбарыг хамарч эрч хүчтэй хөгжсөн.

1921 оны сүүлчээр хэсэг сэхээтэн санаа зорилгоо нэгтгэж, улс орныхоо хоцрогдлыг арилгах, ард түмнээ соён гэгээрүүлэх, бичиг үсэг, соёл боловсролтой болгохын тулд шинжлэх ухааны зүйл бүрийн салбарыг үүсгэн хөгжүүлэх зорилго бүхий Номын (Судар бичгийн) хүрээлэн байгуулах санал боловсруулж Ардын засгийн газарт өргөн барьсан нь өнөөгийн Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн үндэс суурь болсон билээ.⁵⁴ Ийнхүү үндэсний сэхээтнүүд шинэ Монгол улсын ард түмнийг гэгээрүүлэх ажилд гар бие оролцсон бөгөөд шинэ мэдлэг, ойлголтыг монгол хэлээр хүргэхэд орчуулга чухал үүрэг гүйцэтгэсэн байгаа юм. Мөн цаг үеийн шаардлагаар сэхээтнүүд орчуулагч болж байсан тухайд “... энэ үед орчуулга шинэ шатанд гарч, цаг үе олон авьяаслаг орчуулагчдыг төрүүлэн гаргасан ... 30-аад онд би хөгжимчин болох хүсэлтэй байлаа. Гэтэл намайг “чи хүссэнээ хийх биш, хэрэгтэйгий нь хийх шаардлагатай байна” гээд театрын орчуулагч болгосон юм” хэмээн ахмад орчуулагч Э. Оюун дурсжээ.⁵⁵

1913 оноос “Шинэ толь” сэтгүүлд, 1915-1920 оны хооронд “Нийслэлийн хүрээний сонин бичиг” сонинд дэлхийн байдал, олон орнуудын түүх, аж ахуй, зан заншлын тухай нийтлэг мэдээлэл гардаг байсан. “Шинэ толь” сэтгүүлд Леон Каны (Lion Cahun) “Хөх Монголын Хөх Туг” (La bannière bleue) хэмээх түүхэн романы хэсэг нийтлэгджээ. Энэ нь өрнө зүгийн утга зохиолоос орчуулагдсан анхны үргэлжилсэн үгийн зохиол хэмээн үзэж болох юм.⁵⁶ Уг зохиолыг Судар бичгийн хүрээлэнгийн эрхэлсэн сайдын алба хашиж байсан Ж.Цэвээн орчуулжээ. Тэрбээр Жюль Верний “Арван таван наст капитан” хэмээх адал явдалт романыг 1937 онд орос хэлнээс монгол бичиг рүү орчуулсан бөгөөд уг зохиолыг 2 дахь удаагаа 1959 онд хэвлүүлэн өсвөрийн залуу уншигчдад өргөн барьсан юм.

Энэ үед эрдэмтэн, зохиолч Б.Ринчен, зохиолч, орчуулагч Д.Нацагдорж, орчуулагч Ж.Цэвээн, Б.Энэбиш, Г.Дамдин, Н.Жамбалсүрэн, Ж.Намсрай, Ш.Доржготов, Д.Самдан, зохиолч, орчуулагч Ч.Чимид, Ц.Цэдэнжав, Д.Сэнгээ нар голлох үүргийг гүйцэтгэжээ. Тэд намын үзэл бодлыг ард түмэнд хүргэх, шинээр тогтсон Хувьсгалын үйл явцыг дэмжих, хүмүүсийг боловсруулан мэдлэгийг нь дээшлүүлэх, танин мэдэхүйн чиглэлийн бүтээлийг сонгон орчуулж байсан нь тохиолдлын чанартай бус, нийгмийн хэрэгцээ, шаардлагыг ухамсарлаж байсныг харуулж буй юм.

Их эрдэмтэн Б.Ринчен Ги дө Мопассаны “Гар”, “Өвгөн”, Альфонс Додегийн “Алтан тархитай хүний домог” өгүүллэгийг нь 1935 онд орчуулж

⁵⁴Гүрбазар Р, *Орчуулгын онол, дадлагын үндэс*, УБ, 1996, 58-р тал.

⁵⁵Дашдаваа Д, М. *Горькийн зохиолын монгол орчуулгын тухайд*, УБ, 1984, 18-р тал.

⁵⁶Гүрбазар Р, *Орчуулгын онол, дадлагын үндэс*, УБ, 1996, 58-р тал.

“Шинэ толь” сонины 1, 2-р дугаарт, 1944 онд Бомаршегийн “Ухаангүй өдөр буюу Фигарогийн гэрлэсэн нь” жүжгийг орчуулж “Цог” сэтгүүлд хэвлүүлж Францын жүжгийн зохиолын орчуулгын эхийг тавьсан гэж үзэж болохоор байгаа юм.

Монголын шинэ үеийн утга зохиолыг үндэслэгч Д.Нацагдорж Альфонс Додегийн “Алтан тархитай хүний домог”, Мопассаны “Аглагч”-ийг орос хэлнээс тус тус орчуулжээ. Энэ үед 50 гаруй франц бүтээлийг монголчилсоны дотор 10 гаруй роман, 2 жүжиг, 4 тууж, 2 туурь, 9 өгүүллэг, 9 шүлэг, 1 найруулал, 1 дуу орчуулсан гэсэн тоо гардаг.

Энэ үеийн бас нэг онцлог бол 1945 оноос Монгол улсын гадаад харилцаа эрс өргөжихийн хэрээр франц хэлтэй үндэсний боловсон хүчин бэлтгэх цаг үеийн шаардлага гарч ирсэний дагуу ЗХУ-д франц хэлтэй мэргэжилтэн бэлтгэх үндэс тавигдаж Б.Хэнмэдэх, Г.Батсүх, Ж.Намсрай, Т.Пүрэвжал нар төгсчээ.

1950 он хүртэл шинэ хувьсгалын үйл явцыг ард түмэнд таниулах, танин мэдэхүйн чиглэл зохиолын орчуулга зонхилж байсан бол 1950-1960 оны хооронд нам ард түмэн, энх тайван, эв хамтыг магтан дуулах, энх тайвнаар зэрэгцэн орших, дайны аюулыг сэрэмжлүүлсэн утгатай бүтээлийн орчуулга голлох байр суурь эзэлсэн байдаг. Энэ үед дэлхийн 1, 2-р дайнд оролцож явсан Луй Арагоны “Мянга есөн зуун дөчин зургаан он” шүлгийг Ц.Цэдэнжав, “Шүлэгчээс намдаа” шүлгийг Ж.Намсрай нар тус тус монголчилсон байна.

6.1960-1975 оны үеийн орчуулгын бүтээлийн онцлог

Энэ үед хэл хэлний уран зохиолын орчуулга Монгол оронд ид хүчээ авч байсан бөгөөд ХХ зуунд соёл, эрдэм мэдлэгийн хүрээнд асар их амжилт олсны нэг гол үр дүн бол манай сэхээтнүүд гадаадын олон хэл эзэмшиж эхэлсэн явдал байв. Тавиад оны дунд үе хүртэл манайд голчлон орос хэлээр дамжуулан бусад орны уран зохиолын бүтээлтэй танилцаж байсан байлаа. Энэ бол тухайн нөхцөл байдалд зайлбаргүй туулж өнгөрөх зурвас үе байсан бол яваандаа орос орчуулга хичнээн сайн боловч түүнээс дам орчуулах нь олон талаар сөрөг нөлөөтэй байсан нь амьдралд батлагдсан учраас эх хэлнээс шууд монгол хэлэнд орчуулах эрмэлзэл давамгайлах болжээ.⁵⁷

Монголчууд Европын соёл иргэншилтэй танилцахад Францын сонгодог зохиолчдын зохиол бүтээлүүд чухал үүрэг гүйцэтгэснийг цохон тэмдэглэх хэрэгтэй билээ.⁵⁸

Энэ үед нэгэнт тогтсон хувьсгалын үйл явцыг улам цааш нь бэхжүүлэхийг уриалсан, ард түмний бодит амьдралыг харуулсан, хайр дурлалыг магтан дуулсан агуулгатай дэлхийн сонгодог зохиолыг франц эхээс нь орчуулах явдал хүчээ авч эхэлсэн байдаг. Дэлхий дахинд алдаршсан Жюль Верн, Ги дө Мопассан, Анатолий Франс, Виктор Гюго, Стендаль, Оноре дө Бальзак, Проспер Мериме, Раблэ, Эмиль Зола, Жорж Сименон, Альфонс Доде, Александр Дюма

⁵⁷Гүрбазар Р, *Орчуулгын онол, дадлагын үндэс*, УБ, 1996, 72-73 дахь тал.

⁵⁸Оюунгэрэл Л, *Монгол Францын харилцаа*, УБ, 2003, 85-р тал.

зэрэг зохиолчдын бүтээлийг орчуулагч Ж.Намсрай, Т.Пүрэвжал, С.Адидхүү, Т.Төмөрхүлэг, Ц.Батцэвэл, Д.Даш, Ш.Очирбат, М.Цэдэндорж, Г.Амар, Б.Хэнмэдэх, П.Намсрайжав, Л.Чойжилсүрэн, С.Цэрэнрагчаа, Г.Аким нар монголчилсон.

1963 оноос МУИС-ийн Хэл бичгийн факультетад багш орчуулагчийн мэргэжлээр франц хэлний мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн нь эх хэлнээс орчуулах явдалд дөхөм болжээ. Б.Пүрэвбаатар “Монте-Кристо гүн”, “Инээмтгий хүн” зэрэг романыг франц хэлнээс өмнө орчуулсан эхтэй нь тулган дахин орчуулсан байдаг. Мөн эх хэлнээс Ж.Намсрай Анатолий Франсын “Кренкебиль” туурь, “Шүүгчид” өгүүллэг, Гюгогийн “Парисын Дарь эхийн сүм”, “Зоригт далайчид” роман, Стендалийн “Улааныхан ба Харынхан” роман, Бальзакийн “Хүүхэд” өгүүллэг, Флоберийн “Бовари хатагтай” романыг тус тус орчуулан уншигчдын хүртээл болгосон юм.

Энэ үед эрдэмтэн, зохиолч Х.Пэрлээ Францын ардын аман зохиолын баялаг өв, баатарлагийн туульс “Роландын дуулал”-ыг 1969 онд орос хэлнээс орчуулснаар олонд хүрсэн билээ.

Энэхүү алтан үед үргэлжилсэн үгийн роман, тууж, өгүүллэгийн орчуулгын тоо эрс нэмэгдэж 100 гаруй бүтээлээс нь 30 гаруй роман, 2 жүжиг, 50 гаруй өгүүллэг, 6 тууж, 1 туурь, 1 дуу, 5 шүлэг, 2 найраглал зэрэг уран зохиолын бүхий л төрлийн орчуулга байгаа нь харагдаж байна. Жил алгасалгүй аль нэгэн орчуулгын бүтээл уншигчидад хүрч байсан нь ихээхэн онцлогтой явдал юм.

в. 1975- 1990 онхүртэлхүеийнорчуулгын онцлог

Өмнөх үеийг бодоход жил бүр орчуулгын бүтээл олны хүртээл болоогүй хэдий ч монголчилсон бүтээлийн ихэнхийг франц эхээс буулгасан. Д.Пүрэвдорж, Т.Төмөрхүлэг, Б.Пүрэвбаатар, Ц.Сүхбаатар, С.Дулам зэрэг франц хэлт орчуулагчид орчуулгыг эрхлэх болсон нь онцлог явдал болов.

Өрнө зүгийн уран зохиолын орчуулгын ажил нэлээд цэгцэрч, орчуулагчдын тоо өсч, орчуулгын онолын асуудал хурцаар тавигдах болсон үед орчуулгын чанарыг сайжруулах, орчуулагчдын ур чадварыг дээшлүүлэхэд шүүмж судлал онцгой үүрэг гүйцэтгэх болсон байна. 1972 оноос эхлэн гаргасан “Орчуулах эрдэм” цуврал бүтээл бүх хэлний орчуулгын бүтээлийн шүүмж судлалд үнэтэй хувь нэмэр оруулж ирлээ.

Францын уран зохиолыг орчуулах ажил үргэлжлэн, төрийн шагналт, зохиолч Д.Пүрэвдорж МУИС-ийн франц хэлний оройн ангид суралцан Пуррагийн “Урт хамарт гүнжийн үлгэр” гэх үлгэрийн номыг франц хэлнээс, Т.Төмөрхүлэг “Ертөнцийн нэгэн гал голомтын түүх” хэмээх өгүүллэгийн түүвэр 1976 онд франц хэлнээс, М.Шатар “Балар цагийн хуучин явдал” романыг 1978 онд тус тус орчуулжээ.

Орчуулагч Ц.Сүхбаатар “Франц өгүүллэгүүд” хэмээх өгүүллэгийн түүвэр 1980 онд, Шарль Перрогийн “Үлгэрүүд” түүврийг 1983 онд тус тус хэвлүүлсэн байдаг.

МУИС-д бэлтгэгдсэн анхны монгол мэргэжилтний нэг, орчуулагч Б.Пүрэвбаатар 1978 оноос Улсын хэвлэлийн нэгдсэн редакцид орчуулагч-редактор хийх үеэс францын шилдэг бүтээлийг сорчлон орчуулж эхэлсэн юм. Додегийн “Тартарен Альпийн нуруунд” (1982), Меримегийн “Коломба” (1983), “Зуурдын тамын сүнс” (1983), “Давхар алдаа” (1983), Мопассаны “Монт-Ориол”(1983), Сименоны “Шар нохой” (1985), “Хүний амь” (1985), “Негрийн хороолол”(1985), Дюмагийн “Монте-Кристо гүн” (1990), Гююгийн “Инээмтгийн хүн”(1985) зэрэг роман, тууж, өгүүллэг гаргасан байдаг.

Дидрогийн “Гэлэнмаа” гэх алдарт романыг Т.Төмөрхүлэг франц хэлнээс 1984 онд орчуулж гаргасан нь уншигчдийн анхаарлыг зүй ёсоор татсан юм.

С.Дулам Бодлерийн “Үдшийн дуурьсал”, “Этгээд анхилуун”, “Бүсгүйн салхинаа” гэх шүлгийг анх орчуулан “Утга зохиол, урлаг” сонинд 1988 онд хэвлүүлжээ.

Энэ үед бичлэгийн шинэ төрөл эссэ, нийтлэл, сургааль үгс, абстракт жүжгийг уншигчдад өргөн барьсан. 200 гаруй бүтээлийг монголчилсон хэдий ч үргэлжилсэн үгийн романы тоо эрс цөөрсөн нь харагдаж буй юм. 1975 оноос 1990 он хүртэл тасралтгүй орчуулгын ажлыг эрхэлж байсан хэдий ч 1990-ээд оны нийгэм, улс төрийн өөрчлөлтийн гадуур орчуулгын салбарүлдээгүй. 90-ээд оны эхэн үед голдуу садар самуун, адал явдалт өгүүллэгийн орчуулга зонхилж, танин мэдэхүйн шинжтэй зохиолын орчуулга бараг зогсонги байдалд орсон нь орчуулгын зохиолыг орчуулахнэгдсэн бодлого үгүйлэгдэж байсныггэрчилнэ.

г. 1990 оноос өнөөг хүртэл

Нийгэм, улс төрийн огцом өөрчлөлт болсноор гадаадын уран зохиолыг нэгдсэн нэг бодлоготой орчуулах бодлого алдагдаж эхэлсэн. Энэ үеийн нэг онцлог гэвэл урьд өмнө хэвлэгдэж, олны хүртээл болж байгаагүй, өмнөх нийгэмд хориотой байсан сэдвийг хөндсөн, эсвэл, дэлхийн утга зохиолын салбарт онцгой үүрэг гүйцэтгэсэн зохиолчдын бүтээлийг сонгон орчуулах хандлага түлхүү байв.

90-ээд оны дунд үеэс Францын орчин үеийн зохиолчдын бүтээлийн орчуулга мэр сэр харагдах болов. Артур Рамбо, Поль Верлэн, Жак Привер, Гийом Аполлинер, Самуэл Беккет зэрэг орчин үеийн утга зохиолын бүтээлийн шинэ урсгалын бүтээл орчуулгыг чимэх болсон байна.

Монгол улсын гурав дах Ерөнхийлөгч асан Н.Энхбаярын санаачилгаар Дэлхийн сонгодог утга зохиолын 50 боть номыг хэвлүүлэхэд францын Вольтерийн “Жамаараа яваа ертөнц”, Дидрогийн“Гэлэнмаа”, Оноре де Бальзакийн “Эцэг Горио”, “Гобсэк”, В.Гююгийн “Парисын Дар эхийн сүм”, Г.Флоберийн “Бовари хатагтай”, Сартрын “Үг ба бусад зохиолууд”, Камюгийн “Этгээд хвн”, С.Беккет, Ю.Ионеско, А.Арто нарын “Абсурд театр” гэх зохиолыг сонгон дахинхэвлэсэн байна.

Орчуулагч А.Баасандорж асар богино хугацаанд “Суутны үхэл”(2005), “Шувуудын үүрнээс дурлалын жиргээ дуурсана” (2005), “Ялалтын роман”(2006), “Алтан нохой” (2007), “Диана, зүрх сэтгэлийн гүнж” (2009), “Согтуу хөлөг

онгоц” (2009) номыг франц хэлнээс тус тус орчуулан хэвлүүлсэн байна. 2009 онд “Согтуу хөлөг онгоц” ном хэвлүүлж “Алтан өд” шагналын орчуулгын төрлийн шилдэг бүтээлээр шалгарсан.

Зохиолч, орчуулагч Ю.Аюурзана францын алдарт зохиолч, үргэлжилсэн үгийн зохиолч Мишель дө Монтений “Сонгомол эссээнүүд”-ийг англи эхтэй нь тулган 2004 онд монголчилжээ.

Дэлхийн хүүхдийн зохиолын сор бүтээлийн нэг Санкт-Екзюперийн “Бяцхан хунтайж” зохиолыг орчуулагч Ц.Сүхбаатар 2001 онд орчуулж, 2008 онд дахин хэвлүүлсэн. Уг бүтээлийг Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Ном”, “Авьяас” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Ерөнхий боловсролын сурагчдын унших ёстой номын жагсаалтанд багтаан гурав дах удаагаа хэвлэсэн нь хүүхэд багачуудын унших дуртай номын нэг болсон юм.

2007 онд Нээлттэй нийгэм форум, “Монсудар” хэвлэлийн газраас Монголын нийгэмд хэрэгцээтэй, үлгэр жишээ болохуйц ном сурах бичиг орчуулах төслийг Франц хэлний монгол багш нарын холбоотой хамтран хэрэгжүүлсэн билээ. Францын улс төр судлаач Морис Дювержегийн “Улс төрийн байгууламж, үндсэн хуулийн эрхзүй” нэртэй онолын номыг франц хэлнээс орчуулахад Г.Баялаг-Эрдэм, Л.Бямбадолгор, Г.Цэвэлсүрэн, Д.Алтанцэцэг, Д.Баасанжаргал, Б.Алтангүл, Г.Буяннэмэх, Г.Сарнай, О.Тунгалаг нар оролцон, орчуулагч Т.Төмөрхүлэг хянан тохиолдуулж хамтын бүтээл туурвисан билээ.

2010 онд Сартрын “Огиудас” зохиолыг Б.Баттогтох орчуулсан. М.Отгонбаяр, Б.Онон нар феминизмийн үзлийг дэлхий нийтэд таниулсан Симон дө Бовуарын “Дайвар хүйстэн” зохиолыг орос, англи эх сурвалжаас нь харьцуулан орчуулжээ.

2010 онд Монсудар хэвлэлийн газраас Нобелийн шагналт зохиолчдын бүтээлийг орчуулах ажлыг санхүүжүүлэн дэмжсэн тул 2008 оны уран зохиолын салбарын шагналт Францын зохиолч Лө Клезюгийн “Алтан загас” романыг Б.Алтангүл орчуулж олны хүртээл болгосон байдаг.

Энэ бүхнээс авч үзэхэд ХХ зуунд Францын уран зохиолын орчуулгын эх суурь баттай тавигдаж, Монголын орчуулгын уран зохиолын салшгүй нэг хэсэг болсон байна.

Ашигласан бүтээл:

- Б. Алтангүл, *Répertoire des oeuvres françaises traduites en langue mongole*, УБ, 2004.
- Б. Алтангүл, *Францын уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан туршилага*, нэг сэдэвт зохиол, УБ, 2004.
- Ш. Базар, *БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиол, утга зохиол судлалын ном зүй*, 1974, 1976, 1978, 1983, 1987.

- М. Баянзул, *1921-1955 онд Монгол хэлэнд орчуулсан гадаад уран зохиолын бүртгэл*, УБ, 1957.
- Д. Галбаатар, *Уран зохиол, онол, түүх, шүүмжлэл нэвтэрхий толь*, УБ, 2012.
- Р. Гүрбазар, *Орчуулгын онол, дадлагын үндэс*, УБ, 1996.
- Д. Дашдаваа, *М. Горькийн зохиолын монгол орчуулгын тухайд*, УБ, 1984.
- Ж. Намсрай, *Францын утга зохиолын түүх*, УБ, 1997.
- Л. Оюунгэрэл, *Монгол, Францын харилцаа*, УБ, 2003.

Résumé

La traduction est inscrite dans la culture mongole depuis des temps immémoriaux. Il n'est pas étonnant que, parmi les premières œuvres françaises traduites en mongol, ait figuré *La Chanson de Roland* traduite par Kh. Perlee (1960), moins encore que parmi elles figure le roman historique de Léon Cahun, *La bannière bleue* dont le héros est Gengis khan. En 1913, ce premier ouvrage français a été publié en langue mongole par J. Tseveen, un des traducteurs expérimentés du russe en ancienne écriture mongole.

Depuis, plus de quatre cents œuvres de la littérature française, tous genres confondus et donc des romans, des nouvelles, des récits, des pièces de théâtre, de poèmes, des chants, des contes, des essais, ont été traduites en langue mongole directement du français ou à partir de version russe entre 1913 et 2016.